



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их  
сургууль, Гадаад хэлний сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэлний орчуулга (Англи хэл) бакалаврын зэрэг  
олгох сургалтын хөтөлбөр

Индекс:

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Нармандах

Гишүүд: Н.Оюунцэцэг

Д.Энхжин

Он сар өдөр: 2023.12.24

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Оюутнуудын нэрс

II. Багш, ажилчдын нэрс

III. Төгсөгчдийн нэрс

IV. Ажил олгогчдын нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

-

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, Гадаад хэлний сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Гадаад хэлний орчуулга (Англи хэл) бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр	
<b>Индекс</b>		
<b>Шинжээчид</b>	Ахлагч: Глобал Удирдагч Их сургуулийн Ахисан түвшний сургуулийн захирал Д.Нармандах Гишүүн: Хүмүүнлэгийн Их сургуулийн Англи хэлний тэнхимийн дэд профессор Н.Оюунцэцэг Боловсрол, Соёл, Эрх зүйн дээд сургуулийн захирал Д.Энхжин	
<b>БМИҮЗ-ийн зохицуулагч</b>	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч П.Оргилмаа	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2023.11.24	Шинжээчтэй гэрээ байгуулж, тайлан материал хүлээн авах
	2023.12.01	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайлан илгээх
	2023.12.04-05	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2023.12.13	Шинжээчийн үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2023.12.14	Мэргэжилтэн тайланг сургуульд илгээх
	2023.12.15	Сургууль саналаа өгөх
	2023.12.20	Тайланг эцэслэх
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

ШУТИС нь 2018 оноос өөрийн үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандарт ISO9001:2015 болон Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO21001:2018 стандартыг тус тус хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулж, 2023 оны 1 сард Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO21001:2018 стандартын гэрчилгээ авсан.

Гадаад хэлний сургууль нь 1995-1996 оны хичээлийн жилээс “Орчуулагч, инженер” мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн. 2016-2017 оны хичээлийн жилээс гадаад хэлний орчуулга (англи хэл) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Улс орны хөгжлийн бодлого, инновацийн бодлого, хэлний бодлогыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоход шаардлагатай хэлний болдоод техникийн цогц мэдлэгтэй, төрөлх болон гадаад хэл дээр харилцах соёл, ур чадварыг эзэмшсэн, хариуцлагатай, багаар ажиллах чадвартай мэргэжилтэнг бэлтгэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Сургалтын хөтөлбөрийг сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ, ирээдүйн чиг хандлагад уялдуулах, оюутанд сурахад уян хатан нөхцлийг бүрдүүлэх, хичээл хоорондын залгамж холбоог хангах, хичээлийн агуулгын давхардлыг багасгах зорилгоор хөтөлбөрт 3 удаа шинэчлэл өөрчлөлт хийсэн. Ингэхдээ 2019 онд сургалтын хөтөлбөрийг үр дүнд суурилсан боловсрол (ҮДСБ)-ын тогтолцооны дагуу суралцахуйн үр дүнгийн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулсан.

Хөтөлбөрт 2017-2022 хүртэлх хугацаанд уг хөтөлбөрт 125 оюутан элсэн орж 71 хүн төгсч, одоогийн байдлаар 60 оюутан суралцаж байна.

Уг хөтөлбөрийг 19 багш хэрэгжүүлж байгаа бөгөөд багш нарын дийдлэх хуийг 41-ээс дээш насны, 16-аас дээш жил боловсрол, шинжлэх ухааны байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан, дадлага туршлагатай, 40% нь докторын 60% нь магистрын зэрэгтэй байна. Тус хөтөлбөрт АНУ-аас мэргэжилтэн багш урьж ажиллуулж байгаа нь суралцагчдад эх хэлтэнтэй ярилцаж хэлний мэдлэг чадвараа дээшлүүлэхээс гадна, англи болон америкийн ёс заншил, уламжлал, түүх, соёлтой танилцаж англи хэлтэй улс орны иргэдтэй харилцахад нь мэргэжлийн тус дэм болох багшлах бүрэлдэхүүнийг бүрдүүлсэн.

ГХС-ийн бүрэлдэхүүнд 2012 онд Англи хэлдний академи байгуулагдсан бөгөөд 2013-2021 оны хооронд TOEFL, ITP, GRE, Praxis, Pearson VUE (GMAT болон 80 гаруй мэргэжлийн), SAT, ACCA, TOEFC, ACT (Япон улс руу засгийн газар хоорондын гэрээгээр ажиллах хүмүүсээс авдаг шалгалт) PTE, IELTS зэрэг олон улсын түвшний олон шалгалтуудыг авах эрх авч үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү хөтөлбөр нь Монгол улсын эдийн засгийн ялангуяа аж үйлдвэр, геологи, уул уурхай, эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны зэрэг бүхий л салбарын техник, технологийн чиглэлээр мэргэшсэн орчуулагчаар хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

## **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

### **Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг Тогтвортой хөгжлийн бодлого 2030, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэн боловсруулсан байна.
- Монгол улсын эдийн засгийн ялангуяа аж үйлдвэр, геологи, уул уурхай, эрчим хүч, мэдээлэл харилцаа холбоо зэрэг салбарт мэргэжлийн англи хэлний мэдлэгтэй орчуулагчийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байна. 2016 оноос Гадаад хэлний орчуулагч (англи хэл) хөтөлбөрөөр Техник технологийн орчуулагч мэргэжлийн хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлж байна.
- Гадаад хэлний орчуулагч (англи хэл) хөтөлбөрт STEEP шинжилгээг хийж давуу болон сул тал, боломжийг судалсан.
- Ижил төрлийн хөтөлбөр санал болгодог дотоодын (МУИС, ХИС, Мандах их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургууль, Орхон их сургууль, Хүрээ дээд сургууль), гадаадын (Солонгосын Сөүлийн их сургууль, Австралийн Нью Кастлийн их сургууль) зэрэг нэр бүхий их сургуулиудийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийсэн.
- ШУТИС-с нэгдсэн хэлбэрээр зохион байгуулдаг сэтгэл ханамжийн судалгаанаас гадна хэрэглээний хэл шинжлэлийн тэнхимээс оюутны сэтгэл ханамжийн судалгааг сүүлийн 3 жил тогтмол (2019-2022) зохион байгуулж, үр дүнг хөтөлбөрийн хэрэгжилтэд тусгаж ажиллаж байна. Жишээлбэл, оюутнуудын зүгээс орчуулгын үйлдвэрлэлийн дадлагын хугацааг өөрчлөх, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ирээдүйн ажлын байрны талаар зөвлөгөө авахад чиглэсэн карьер хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх саналуудыг гаргаж, тэнхимийн зүгээс ажил хэрэг болгожээ.
- Техник технологийн орчуулагч мэргэжлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилгоор оюутнуудын танилцах дадлага хийх үед тухайн байгууллагуудаас санал асуулга зохион байгуулж суралцагчдад ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг анхааран ажилладаг. *(ГХС-н танилцах дадлага хийлгээж буй байгууллагаас авах санал асуулга)*
- Хамтран ажиллагч байгууллагуудын хүсэлт, эрэлт хэрэгцээг судалж, сургалтын агуулга, аргазүйд тусгаж байна. *(Хавсралт 1.2. Хамтран ажиллах хүсэлт)*

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Техник, технологийн чиглэлээр дагнасан хөтөлбөр хэрэгжүүлж, төгсөгчид нь хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байдаг.
- Англи хэлний хэлзүйн болон орчуулгын хичээлд хэрэглэгдэх сурах бичгийг өөрсдийн туршлага дээр үндэслэн боловруулж, сургалтад хэрэглэдэг.
- Суралцахуйн үр дүнг суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаар үнэлдэг болгож өөрчилснөөр оюутнуудад зөөлөн ур чадварыг эзэмшүүлэх таатай боломж бүрдсэн байна.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030- н зорилт V, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) –д заасан ШУТИС-н оролцоог өрсөлдөх чадвартай мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, мэдлэг-инновацад суурилсан “судалгаа-үйлдвэрлэл-үйлчилгээ” –г хөгжүүлэхийг зорилго болгон тодорхойлсон байгаатай уялдуулан ШУТИС-н стратеги төлөвлөгөөнд тусгасан.
- Хөтөлбөрийн зорилго боловсруулахад ШУТИС-н алсын хараа, эрхэм зорилго, чанарын бодлоготой уялдуулж, бүрэлдэхүүн сургуулиуд хамт олноороо хэлэлцэн, өөрсдийн эрхэм зорилгоо тодорхойлж, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд тусгаж өгсөн байна.
- ГХС нь Техник технологийн орчуулга чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг Монгол улсын их, дээд сургуулиуд дунд сургалт, заах арга, эрдэм шинжилгээний ажлаар тэргүүлэн, мэдлэг чадвартай техникийн орчуулагч бэлтгэх эрхэм зорилгыг тодорхойлжээ.
- Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хөтөлбөр хэрэгжүүлж буй багш нарын санал, санаачилгыг салбарын хурлаар хэлэлцэж ажил хэрэг болгох зорилгоор холбогдох нэгжүүдтэй хамтран ажилладаг.
- Суралцагч, төгсөгч, ажил олгогчдоос санал асуулга авах хэлбэрээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлдог. ШУТИС-н хэмжээнд төгсөгчдийн мөшгих судалгаа, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол зохион байгуулдаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн зорилгыг боловсруулахад Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, ШУТИС алсын хараа, эрхэм зорилго, хэлний бодлого, орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулжээ.
- Хөтөлбөрийн зорилгод ажил олгогчдын эрэлт хэрэгцээг судалж, тусгадаг нь хөтөлбөрийн өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлж байна.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”, ШУТИС-н Эрдмийн зөвлөлийн 2016 оны 06-р сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэж “Гадаад хэлний орчуулга (англи хэл)” бакалаврын сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна.
- Сургалтын хөтөлбөрийн бүтэц дэх хичээлүүдийг 2019 онд CDIO стандартын шаардлагад нийцүүлэн өөрчилж, хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлж, хичээл хоорондын агуулгыг давхардлыг арилгаж, сурах бичигт өөрчлөлт оруулсан байна.
- Гадаад хэлний орчуулагч (англи хэл) хөтөлбөрийн хувьд инженер техникийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг суралцахуйн үр дүнг, өөрийн хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлон мөрдөж байна.
- Сургалтын төлөвлөгөөний дагуу Ерөнхий суурь 36 кредит (*заавал судлах 30 кредит, сонгон суралцах 6 кредит*); Мэргэжлийн суурь хичээл 41 кредит (*заавал судлах 35 кредит, сонгон судлах 6 кредит*); Мэргэжлийн хичээл 48 кредит цаг (*заавал судлах 33 кредит, дадлага 4 кредит, дипломын ажил, төгсөлтийн шалгалт 5 кредит, сонгон суралцах 6 кредит*).
- “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэхэд баримтлах журам”-г баримтлан суралцагчдыг үнэлэхийн зэрэгцээ тэдний суралцах чадамж, хувь хүний харилцаа, багаар ажиллах зэрэг зөөлөн ур чадваруудыг үнэлэх рубрик боловсруулан сургалтад хэрэглэж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаад хэлний орчуулагч хөтөлбөрт хөтөлбөрийн суралцауйн үр дүн- 4, хичээлийн суралцахуйн 17-н үр дүнг CDIО инженер техникийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдтэй, мөн АВЕТ буюу инженер технологийн магадлан итгэмжлэлийн зөвлөлийн шалгуур үзүүлэлтүүдэд тус тус нийцүүлэн боловсруулан сургалтын хөтөлбөрт тусгаж байна.
- Сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлт сайжруулалт хийх бүрд сургалтад хэрэглэх гарын авлага, сурах бичгийг сайжруулан боловсруулж сургалтад хэрэглэж байна. Энэ хүрээнд ШУТИС-н 100 үндсэн сурах бичигт “Хэл зүй, үгсийн сан 1-4”, “Шинжлэх ухаан технологийн англи хэл 1, 2” хичээлүүдийн сурах бичгийг бичиж 2021 оны 5-р сарын 19 ний Гадаад хэлний сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлаар баталсан байна.
- Мөн 21-р зууны чадамжийг тусгайлан судалж, хөтөлбөр болон хичээл тус бүрийн хүрээнд хөгжүүлэх зорилготой ажиллаж байна

#### **Анхаарах асуудал:**

- Магадлан итгэмжлэл хийлгэж буй сургалтын хөтөлбөр нь 2016 онд БСШУ-н сайдын А/174 тоот тушаал болон ШУТИС- н хөтөлбөр боловсруулах журмын дагуу боловсруулсан хөтөлбөр байна. Тус хөтөлбөрийг 2019 онд шинэчлэн боловсруулж сургалтад хэрэглэж байгаа бөгөөд шинэ хууль, журамд нийцүүлэн 2023 онд шинэчилсэн хөтөлбөрийн загвар хийгдсэн байгааг тайланд тодорхой тусгаж оруулах

#### **Зөвлөмж:**

- Сургалтын хөтөлбөрт орсон өөрчлөлт бүрийг баримжуулж, өөрчлөлт хийх болсон шалтгаан, үндэслэл, анализ зэргийг хангалттай тусгаж байх

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**



- Гадаад хэлний орчуулга (англи хэл) бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын үйл ажиллагаанд ШУТИС-н бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журамд үндэслэн зохион байгуулдаг.
- Гадаад хэлний орчуулга (англи хэл) бакалаврын хөтөлбөр нь мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалтын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжил, сургалтын орчинд тавих үндсэн шаардлагыг тодорхойлдог стандарттай, түүнд нийцсэн сургалтын төлөвлөгөөтэй байна.
- Техник, технологийн орчуулга (англи хэл) мэргэжил нь оюутнуудад 45 төрлийн 125 кредит цагийн хичээлээр мэдлэг, чадвар олгож, хандлага төлөвшүүлж байна. Сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалтыг дараах байдлаар төлөвлөжээ. Ерөнхий суурь заавал судлах 36 кредит буюу 28.8%; Мэргэжлийн суурь хичээл 41 кредит буюу 32.8% Мэргэжлийн хичээл (*дадлага, диплом, төгсөлтийн ажил*) 39 кредит буюу 38.4%
- Сургалтын хөтөлбөрөөр судалдаг заавал судлах 35 хичээлийн 12 нь лекц, семинар хосолсон; 23 хичээл дан практик хэлбэрээр явагддаг нь уг хөтөлбөрөөр оюутны бие даан судлах боломжийг нэмэгдүүлж байна.
- Гадаад хэлний орчуулагч (англи хэл) хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө нь оюутан хичээл, хичээл судлах улирлаа өөрөө сонгох боломжтой, уян хатан боловсруулагдсан тул зарим оюутан 3,5 жилд багтаан хичээлээ судлаж дуусдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн онцлог болох “Шинжлэх ухаан технологийн орчуулга” хичээлийг 4 улиралд ШУТО 1-4 гэсэн хэлбэрээр зааж байна. Ингэхдээ ШУТО-1 нь Мэдээлэл харилцаа, технологи; ШУТО-2 нь хүнс биотехнологи, ШУТО-3 нь зам, барилга, архитектор, ШУТО - 4 нь эрчим геологи уул уурхайн чиглэлээр тус тус мэргэшсэн орчуулга хийх боломжийг хангаж байна.
- Мөн шинжлэх ухаан технологийн орчуулга хичээлийн сурах бичиг, хэрэглэгдэхүүнийг боловсруулж, байнга шинэчлэн сайжруулж сургалтад хэрэглэж байгаа нь онцлог байна.
- Гадаад хэл орчуулга (англи хэл) хөтөлбөр нь чөлөөт сонголт хийх боломжийг олгодог учраас бусад мэргэжлээр суралцаж буй оюутнууд орчуулагчийн мэргэжлийн хос мэргэжил болгон судлах байдал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн.

## **2.2 Сургалтын арга зүй**

**Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл харилцааны дэвшилтэт технологи ашигладаг байна.**

#### **Илрэл нотолгоо:**

- Хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион явуулах талаар сургууль болон тэнхимийн зүгээс анхаарал тавьж ажилладаг бөгөөд хичээлийн анги танхимуудад орчин үеийн технологийг хэрэглэж, сургалтыг интерактив хэлбэрээр зохион байгуулах бүрэн боломжтой болсон байна. Үүнд, хичээлийн анги тус бүр телевиз, компьютер, зарим ангиудад таблет зэргээр бүрэн тоногдсон.
- Хэрэглээний хэл шинжлэлийн сургуулийн зүгээс багш нарын заах арга, ур чадварыг сайжруулах зорилгоор ихээхэн анхаарч ажилладаг бөгөөд энэ хүрээнд багш CDIO арга зүйн сургалтад тогтмол хамрагдаж байна. Жишээлбэл, тайлант хугацаанд нийт 281 сургалтад багш нар хамрагджээ.
- Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг боловсруулахад CDIO аргазүйг баримталдаг тул багш нар CDIO заах аргазүйн болон хөтөлбөр боловсруулах сургалтад хамрагдах нь сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.
- Багш нар сургалтад идэвхтэй сургалтын аргууд болох тонгоруу сургалтын араг, холимог сургалтын арга, хэлэлцүүлэг, төсөлд суурилсан арга зүй зэргийг өдөр тутмын сургалтад өргөнөөр ашиглаж байна.
- Өдөр тутмын хичээл, сургалтын үйл ажиллагаанд ШУТИС-н нэгдсэн платформ LMS, Teams, Moodle, Google classroom програмуудыг ашиглаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаад хэлний орчуулга (англи хэл) хөтөлбөрийн арга зүй нь CDIO аргазүйд үндэслэн боловсруулагдсан тул багш нар сургалтад идэвхтэй аргуудыг өргөн хэрэглэж, оюутнуудын бүтээлч, хийсвэр сэтгэлгээг хөгжүүлэхээр ажилладаг байна.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС-н оюутны мэдлэгийг үнэлэх журам нь 1999, 2003, 2014 онуудад шинэчлэгдсэн.
- Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийн гүйцэтгэлийн түвшинг үнэлэхдээ шууд болон шууд бус гэсэн 2 төрлийн аргыг хэрэглэж байна.
- ШУТИС-н “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах дүрэм”-д заасны дагуу оюутны эзэмшсэн мэдлэгийг 70 хүртэлх оноогоор, улирлын эцсийн шалгалтыг 30 оноогоор тус тус үнэлж байна.

- Гадаад хэлний орчуулга (англи хэл) хөтөлбөрийн оюутнуудын голч үнэлгээ 2020-2021 онд 2.76, 2021-2022 онд 2.37, 2022-2023 онд 2.53 гэсэн үзүүлэлтэй байгаа нь оюутнуудын голч оноо огцом хэлбэлзэлгүй байна.
- 2022 оноос эхлэн оюутны мэдлэгийн үнэлгээг бодитой болгох, оюутны хичээлд оролцож байгаа идэвх, хандлагыг үнэлэх зорилгоор багшийн 70 онооны үнэлгээг 12 нарийвчилсан үнэлгээнд задалж, улмаар зөөлөн ур чадвар, хандлагад харгалзах тоон үнэлгээг даалгаврын гүйцэтгэлтэй холбож өгчээ.
- Үнэлгээнд тестийн, аман, бичгийн, хосолсон хэлбэрүүдийг хичээл тус бүрийн онцлогт нийцүүлэн хэрэглэж байна.
- Оюутны дадлагын үнэлгээг хийхдээ дадлага хийлгэсэн байгууллага 70 оноо, мэргэжлийн багшийн үнэлгээ 30 оноог эзэлж байна. Үнэлгээ хийх рубрик шалгуур үзүүлэлт нь нарийн төлөвлөгдсөн байна.
- Дипломын ажил, төсөлд өгөх үнэлгээний хувьд удирдагч багшийн үнэлгээ 50 оноо, урьдчилсан хамгаалалт 20 оноо, хамгаалалтын үнэлгээ 30 оноо гэсэн хуваарилалттай үнэлж байна.
- Багш өөрийн заасан хичээлийн үнэлгээний хувь, амжилтыг тогтоож, дүн шинжилгээ хийх боломжийг LMS систем нь бүрэн олгодог.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаад хэлний орчуулга (англи хэл) хөтөлбөрийн үнэлгээний хэлбэрт нарийн задаргаа хийж даалгавар тус бүрийн хувьд эзэмшвэл зохих хандлага, зөөлөн ур чадварыг нарийн тусгаж, үнэлгээндээ нэвтрүүлсэн нь шинэлэг байна.
- Төлөвлөгөөтэй, зохион байгуулалт сайтай оюутнуудын хувьд хичээлийн 3.5 жилд багтаан судалж сургуулиа төгсөх боломжтой байна.

### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дээд боловсролын байгууллагад тавигдаж буй нийтлэг стандарт шаардлагад нийцсэн орчныг бүрдүүлэх зорилгын хүжээнд ГХС нь өөрсдийн

нөөц бололцоог ашиглан техник, технологийг шинэчлэх, анги танхимуудын тохижилтыг сайжруулах ажлыг үе шаттай хийж ирсэн.

- Овутан суралцах орчныг стандарт шаардлагад бүрэн нийцүүлэхийн тулд нэг оюутанд ногдох сургалтын талбайг стандарт хэмжээнд, хичээлийн өрөө, лаборатори, кабинтийн нэг суудалд ногдох талбайг зохих журмын хэмжээнд байлгах зорилгоор 1-323, 1-320, 2-612, 2-325, 327, 328 тоот өрөөнүүдийг 23.504.900 төгрөгөөр засаж сайжруулсан.
- Салбарын багш, ажилтан ажлын ширээ, суурин болон зөөврийн компьютер, принтер, сканер, зэрэг тоног төхөөрөм, бичиг хэргийн бусад зүйлээр бүрэн хангагдсан.
- Багш нарын өрөө болон хичээлийн анги танхим утастай болон утасгүй интернетийн сүлжээнд холбогдсон.
- Лекц, практик семинарын ангиудад проектор, ухаалаг самбар, ухаалаг ТВ байршуулж сургалтын цахим болон танхимийн хэлбэрээр явуулах нөхцлийг бүрдүүлсэн.
- Багш оюутанд зориулсан 80 хүний суудалтай хурлын танхим, 150 хүний суудалтай урлаг заал, сдорт заал, нийтийн уншлагын танхим, лекцийн танхим, цайны газар, эрүүл мэндийн төв, хэвлэлийн газар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэвтрүүлэх зориулалттай зам, өлгүүр, цахилгаан шат, машин, унадаг дугуйны зогсоол зэргийг барьж тохижуулсан.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх нөөц ба удирдлагын мэдээллийн системийн байдалд PDCA аргаар шинжилгээ хийн үнэлгээ өгч сайжруулалт хийсэн.
- Сургалтын орчны талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг гаргасан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн барилга нь олон нийтийн БНБД 31 -03-03 –ын 2.7 дахь заалтын нэгдүгээрт заасан хичээлийн байр, анги, кабинетын өрөөний хэмжээ, зохиомол ба байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан хангамж, цонх, хаалга, өрөө тасалгааны будаг, өнгө үзэмж эрүүл аюулгүй ажиллагааны шаардлагад бүрэн нийцсэн.
- Суралцагчдын хэрэглээ, сургалтын хөтөлбөрийн болон дадлагын ажлын үр дүнг чанартай хүртээмжтэй хэрэгжүүлэх зорилгоор техник технологийн нөөц бололцоо хүчин чадлыг жил бүр тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлж, сургалтын лабораториудыг орчин үеийн шинэлэг технологиор ханган ажилладаг байна.

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Багш суралцагчдын сургалтад ашиглаж буй 16 нэр төрлийн 71 ширхэг тоног, төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтыг 2018-2022 оны байдлаар гаргасан.
- Гадаад хэлний орчуулга хөтөлбөрийн хичээлүүдийн сурах бичгийг дээд боловсролын суурь, мэргэжлийн болон мэргэшүүлэх гэж ангилан, англи хэл дээр 28ь орос хэл дээр 10, монгол хэл 38, герман хэл 6 нийт 82 төрлийн ном сурах бичгийн сургалтад ашиглаж байна.
- Уг хөтөлбөрийн хичээл нэг бүрийн сургалтын хэрэглэгдэхүүний судалгааг гаргасан. Сургалтад ашиглагдаж буй үндсэн сурах бичгийн 75.04% (39 ш) нь гадаад, 19.2% (10ш) нь салбарын багш нарын боловсруулсан ном, сурах бичиг, 5,76% (3) нь тараах материал байна. Англи хэлний наруулга зүй, Бичгийн орчуулга (сонгон 2), шинжлэх ухаан технологийн англи хэл II гэсэн үлдсэн 3 хичээлд хэрэглэгдэх сурах бичиг боловсруулж байна.
- Хөтөлбөрийн багш нар 8 сурах бичиг, 6 гарын авлагыг бичиж хэвлүүлэн сургалтад ашиглаж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүх багш нар заадаг хичээлийн агуулгатай холбоотой төрөл бүрийн сургалтын материал зөвлөмжийг боловсруулж, 47 төрлийн хичээлийн лекц, семинар, практик, бие даалтын нийт 1242 файлыг LMS цахим хичээлийн платформ, TEAMS-д байршуулсан байна.
- 2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилд нийт 81 оюутнаас судалгаа авч оюутнуудад тулгамдаж буй асуудлуудыг судлан тогтоож, анализ хийн ажлаа сайжруулах арга хэмжээ авсан байна. Үүний үр дүнд анги танхимыг засварлан тохижуулж, WiFi router, ухаалаг самбар, зурагтыг суурилуулсан.
- Номын хандивын аян өрнүүлсний хүрээнд E-404 тоот “Modern Innovative American Classroom”-д нийт 5:585.500 төгрөгийн ном цугларсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Лекц, семинар, практик, бие даалтын зэрэг хичээлийн агуулгатай холбоотой цахим сургалтын материал бүрдүүлж LMS цахим платформ, TEAMS-д байршуулснаар оюутан орон зай, цаг хугацаанаас үл хамааран хичээл хийх боломж илүү сайжирсан сайн тал байна.
- Сургалтад ашигладаг техник технологи болон програм хангамжийн талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг авч түүндээ үндэслэн оюутны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайжруулалт хийж хэвшиж байгаа нь сайшаалтай.
- Багш нэг бүр шинээр зөөврийн компьютертэй болсон тул цахим танхим хосолсон хэлбэрээр ажиллах боломж бүрэн бүрдсэн.
- Уг хөтөлбөрийн сургалтад ашиглагдаж буй үндсэн сурах бичгийн 75.04% (39 ш) нь гадаад, 19.2% (10ш) нь салбарын багш нарын боловсруулсан ном, сурах бичиг, 5,76% (3) нь тараах материал байгаа бөгөөд эдгээр 3 хичээлд хэрэглэгдэх сурах бичиг

боловсруулж байгаа зэргээс үзэхэд сурах бичгийн хангамжийг системтэй төлөвлөгөөтэйгээр боловсруулж хэвшсэн сайн туршлага байна.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээг ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТНС-д 11.094 ширхэг ном хэвлэл, судалгааны бүтээл байгаа бөгөөд зохиогчийн эрхийн хүрээнд ШУТИС-ийн уншигч нэвтрэх боломжтой.
- Номын сан нь оюуны өмчийг хамгаалах, судалгааны бүтээлийг чанаржуулах зорилгоор 2022 оноос эхлэн төгсөгчдийн судалгааны бүтээлийн хуулбарлалтыг албан ёсоор шалгаж эхэлсэн.
- ШУТИС-ийн 60 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд “ШУТИС-ийн үндсэн сурах бичиг”-ийг бүтээн хэвлүүлэх ажилд ГХС-ийн багш нар оролцож, багш нар хэл ярианы соёл зэрэг суурь болон үндсэн сурах бичгийг хэвлүүлж номын сангийн 700-800 номыг эргэлтэд оруулсан байна.
- Ном сурах бичиг, бусад баримт материал, шинжлэх ухаан, техник, технологи, нийгмийн ухааны мэдээллийг уахим хэлбэрт оруулан ашиглах, цаашлаад онлайн нээлттэй эх сурвалжийг сургалт, судалгаанд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Үүнд:
  - Цахим мэдээллийн сан EBSCO -оор дамжуулан дэлхийн хэмжээнд гарч буй 3000 гаруй сэтгүүлээс хайлт хийж үйлчилж БСШУСЯам, Springer хэвлэлийн газартай 5 жилийн гэрээ байгуулснаар Springer мэдээллийн сангийн 1997 оноос хойших 2409 эрдэм шинжилгээний сэтгүүлийг ашиглах эрхтэй.
  - Springer Nature Олон улсын мэдээллийн сангаас 1800 гаруй ном, 2700 гаруй сэтгүүлээс мэдээлэл татаж авах боломжтой
  - DOAJ Directory of Open Access Books - Дэлхийн 408 эрдэм шинжилгээний салбарын 33731 орчим номуудыг онлайнаар үнэ төлбөргүй орж үзэх, татаж үзэх боломжтой.
  - Thesis – Тус платформд 40100 гаруй эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлийг онлайнаар үнэ төлбөргүй орж үзэх, татаж авах боломжтой.
  - Dimensions- Open Access Filter ашиглан 30 гаруй сая мэдээллээс хайлт хийж, үзэх боломжтой.
  - Hindawi – Эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг үнэ төлбөргүй үзэх боломжтой.
  - Цахим номын сан- ШУТНС-д байгаа e – ном эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэлүүдийг үзэх боломжтой.
  - Судалгааны сан- Докторын зэрэг горилсон бүтээлүүдийн жагсаалт, товч агуулгуудыг онлайнаар үзэх

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Өрөөний хэмжээ, зохиомол ба байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан хангамж, цонх, хаалга, өрөө тасалгааны будаг, өнгө үзэмж эрүүл аюулгүй ажиллагааны шаардлагад бүрэн нийцсэн тохилог номын сантай.
- Ном сурах бичиг, бусад баримт материал, шинэжлэх ухаан технологи, нийгмийн ухааны мэдээллийг цахим хэлбэрт оруулан ашиглах, цаашлаад онлайн нээлттэй сурвалжийг сургалт, судалгаанд ашиглах боломжийг бүрдүүлсэн.

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИСийн хөтөлбөрийн хорооны журмыг 2022 оны 5 дугаар сарын 24 өдөр шинэчлэн баталсан. ШУТИС-ийн хөтөлбөрийн хороо нь ХЕХ, бүрэлдэхүүн, харьяа сургууль төвийн Хөтөлбөрийн дэд хороо ХДХ гэсэн бүтэцтэй байна.
- ХЕХ, ХДХ байгуулагдсанаар боловсролын талаар төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, сургалтын хөтөлбөрийн стандарт, шаардлага, ШУТИС-ийн бодлогын баримт, бичигт тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд нэгдсэн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих, хөтөлбөрийн агуулга, арга зүй, чанар, үр дүн сургалтын орчны нөхцөл мэргэжлийн хөтөлбөртэй уялдаж буй эсэхэд үнэлгээ хийсний үндсэн дээр хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам болсон.
- 2020-2021 оны хичээлийн жилээс ХДХ-д аж үйлдвэрийн газар болон төгсөгчдийн төлөөллийг оруулдаг болсон.
- UNIMIS удирдлагын мэдээллийн системийн ашигласнаар багш, суралцагч удирдлага зэрэг хөтөлбөрийн оролцогч талууд мэдээ, мэдээллийг түргэн шуурхай дамжуулж, хүртээмжтэй ашиглах богино хугацаанд ажлыг гүйцэтгэх давуу талтай болсон.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоо үр өгөөжтэй байлгах талд анхаарах

## **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээнд хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог тогтмолжуулж, идэвхжүүлэх

### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь ШУТИС-ийн салбар сургуулиуд, ШУТИМ-ийн ЭШИГ, ШУТСан болон АНН- орчуулгын ажлын захиалгаар хийдэг. ХХШС-ийн багш нарыг докторантурт суралцуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ШУТИС-ийн салбар сургуулиуд МУИС, МУБИС, ҮБХИС, Орхон их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Монголын залуу эрдэмтдийн холбоотой урт хугацаанд хамтран ажиллаж байна.
- ШУТИС-ийн стратеги төлөвлөгөөний 1.5-р тэргүүлэх чиглэлд багш судлаачдын тасралтгүй хөгжүүлэх, дэмжих тогтолцоог бүрдүүлэх харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь БНСУ-ын Гёнгнам ШУТИС, БНСУ, The Asia Pacific Society, ОХУ-ын Буриадын их сургууль, БНСУ-ын Чонбукийн их сургууль, Чунбүк үндэсний их сургууль, БНХАУ-ын Харбин Технологийн их сургууль зэрэг гадаадын их, дээд сургуультай мэдлэг туршлагаа нээлттэй солилцох хамтын ажиллагааны хүртээмж, эргэх холбоог үр дүнтэй дээшлүүлж байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь Англи хэлний багш нарын холбоо (ELTAM), Орос хэлний багш нарын холбоо (Мон АПРЯЛ), герман хэлний багш нарын холбоо (МГХЖНХ), ШУТИС болон ГХС-ийн төгсөгчдийн холбоотой хамтран сургалт, судалгаа хийх, зах зээл дэх ажлын байрны мэдээлэл, онцлог, хэрэгцээ шаардлагын талаар хурал семинар, спортын тэмцээн зохион зэргээр үйл ажиллагааг явуулдаг байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд дахааь ажлуудыг хийж гүйэтгэсэн бйна Үүнд:
  - ШУТИС-ийн багш, ажилтны 20 хүүхэд, ШУА, ФТХүрээлэнгийн 15 эрдэм шинжилгээний ажилтан, НХЖХ, ОНАБХА-ны Хамгаалалтын газрын ДББХХ-ны 90 албан хаагч, БАТС-ийн докторант, БНХАУ-ын ӨМӨЗО-ны АҮИС-ийн 16 багшид англи хэлний, ХШУС, ГУУС-ийн оюутнуудад герман хэлний сургалт зохион байгуулсан.
  - Үндэсний номын сан болон Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын санд ХХШС-ийн профессор багшийн бүтээлийн дээжээс 40 ширхэг сурах бичиг орчуулгын бүтээл, “Эрхэм баян эрдэм” 4 удаагийн хандивлах



сйн үйлсийн аянаар нийслэл, хот хөдөөд орон нутгийн ЕӨС-д 60 гаруй өрлийн 200 ном, сурах бичиг гарын авлага, зурагт үзүүлэн хандивласан.

- Байгальд ээлтэй байгууллага, хамт олон болох зорилгын хүрээнд багш, оюутнууд 20 удаа мод тарих, хаврын олон нийтийн цэвэрлэгээнд идэвхтэй оролцсон.
- Хөтөлбөрийн төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллаж, менторшип хөтөлбөрийн хүрээнд суралцаж буй оюутнуудад 20 гаруй удаа хөгжлийн сургалт, уулзалт зохион байгуулсан.
- 2019 оноос багш, ажилтан төгсөгчдийн гар бөмбөгийн тэмцээнийг жил бүр уламжлан болгон зохиодог болсон.
- ГХС-ийн пейж хуудсаар амжилттай ажиллаж байгаа төгсөгчдийг алдаршуулж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- 2022-2023 оны хичээлийн жилийн санхүүгийн тайлангаас үзэхэд үндсэн үйл ажиллагааны буюу сургалтын төлбөрийн орлого 20,65%, үндсэн бус үйл ажиллагааны орлого (Эрдэм шинжилгээний орлого /Түр сургалт-2.4%, Англи хэлний академи 10.45%, оюутны үйлчилгээ/бусад орлого 0,95%) – 13.7%, СХТооцооны орлого/санхүүжилт 65.6%, төсвөөс санхүүжих үеийн орлого 0.05% байна.
- 2022-2023 оны хичээлийн жилд 4,473.2 сая төгрөг төсөвлөснөөс нийт 4,412.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.
- Тухайн жилийн нийт зардлын гүйцэтгэлд 2,756.7 сая төгрөг буюу 62.5 хувийг цалингийн зардал, 1,097.6 сая төгрөг буюу 24.3 хувийг сургалтын төлбөрийн төвлөрүүлэлтийн зардал, 260.9 сая төгрөг буюу 5.9 хувийг хичээл практиктийн зардал, 296.8 сая төгрөг буюу 6.7 хувийг бусад үйл ажиллагааны зардал эзэлж байна.
- ГХС -ийн нэг оюутанд оногдох зардлын тооцоог 2018-2022 оны байдлаар зардал нэмэгдсэн гэсэн тооцоо гаргасан.
- ХХШС нь санхүүжилтийн дийлэнхийг сургалтын төлбөр, сургууль хоорондын тооцоо, оюутны үйлчилгээний орлого бүрдүүлэх боловч санхүүжилтийн олон эх үүсвэртэй байх зорилгын хүрээнд байгууллагын захиалгат сургалт, болон оюутнуудад зориулсан эрчимжүүлсэн түр сургалтууд зохион байгуулах болон төгсөгчдийн хандив зэргээр орлогоо бүрдүүлдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

## **Онцлог зүйл/Туршлага:**

- Санхүүжилтийн олон эх үүсвэртэй.

### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС нь 2017 оны хичээлийн жилээс Маркетинг олон нийттэй харилцах албыг шинээр байгуулсан. Энэхүү алба нь мэргэжил сурталчлах, мэргэжил сонголт, мэргэжлийн чиг баримжаа олгох, элсэгчдийн тоог тогтвортой хадгалж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс жил бүрийн 11-р сараас эхлэн “ШУТИС-ийн нээлттэй хаалганы өдөр: Ирээдүйн мэргэжилтэн-Бидний оролцоо” арга хэмжээ зохион байгуулж ирсэн.
- Хөтөлбөрийн сурталчлах маркетингийн арга хэлбэрийг хүснэгтээр харуулсан.

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.**

#### **Анхаарах асуудал:**

- Маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр боловсруулалт, үр дүн
- Элсэлтийн бодлого, үйл ажиллагаанд хөтөлбөрийн онцлог, давуу талаа илүү тодорхойлж түүнд нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах үнэлэх асуудал.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг илүү үр дүнтэй үндэсний хэмжээнд жишиг болохуйц үр дүнд хүргэх маркетингийн бодлого төлөвлөгөө боловсруулах
- Хөтөлбөрийн онцлог, давуу тал, хүрэх үр дүн, хэрэгцээ шаардлага, хөдөлмөр эрхлэх боломж г.м. элсэлтийн үр дүнд нөлөөлөх чухал мэдээллүүдийг үндэсний болон олон хэмжээнд олон нийтэд хүргэх олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, томоохон хэмжээний үзэсгэлэн, мэргэжил сурталчлах өдөрлөг, тэмдэглэлт үйл явдлууд зэрэг олон хэлбэрийн үйл ажиллагааг явуулах

### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ХХШс нь ГХО (англи хэл) хөтөлбөрийн ТТО мэргэжлийн талаар ШУТИМ, ГХС - ийн бэвсайтыг ашиглан элсэлтээс төгсөлт хүртэлх бүхий л мэдээллийг үнэн зөв, ил тод байдлаар хүргэдэг байна.
- ГХС-ийн вэб сайтад сургуулийн болон салбар стэнхимийн танилцуулга, эрдэм шинжилгээ, хатын ажиллагаа, чанарын менежментийн баг, сургалт, оюутанд

чиглэсэн үйл ажиллагаа болон нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж буй ажлууд, онцлох мэдээ зарлалыг байршуулсан байдаг байна.

- ХХШС-ийн цэс дотор салбарын танилцуулга, сургалтын үйл ажиллагаа, бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн болон элсэлтийн танилцуулга, оюутны үйлчилгээ, амжилт, клубуудын танилцуулга гэсэн цэсүүдтэй байна.
- ШУТИС, ГХС-ийн вэбсайтаас гадна нийгмийн сүлжээн дэх пейж хуудсуудаар салбарын профессор багш нарын гаргасан бүтээл зохион байгуулсан ажлын мэдээлэл, сурталчилгаа зэргийг танилцуулж, олны хүртээл болгодог байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ШУТИС-д элсэн суралцахаар хүсэлт гаргагчийн хүсэлтийн дагуу элсэлтийг журмын дагуу зохион байгуулдаг.
- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас тогтоосон шаардлага, орчны болон холбогдох стандартад нийцүүлж СТУЗ-өөс тогтоосон хяналтын тоонд багтааж бакалаврын хөтөлбөрт намар, хавар тус тус элсэлт авдаг.
- Элсэлтийн үйл ажиллагааг [www.elselt.edu.mn](http://www.elselt.edu.mn), [www.must.edu.mn](http://www.must.edu.mn) вебээр нээлттэй, хүртээмжтэй байдлаар дэмжиж ажилладаг.
- Аймаг орон нутгаас элсэгчдийг МИДСК- тай хамтран зохион байгуулдаг ба Бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журамыг мөрдлөг болгодог.
- ГХО хөтөлбөрийн онцлогийг харгалзан элсэгчдийн ЭЕШ- ийн бүлгийг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн 5 дугаар бүлэгт хамааруулж элсэлт авч эхэлсэн байна.
- Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо тайлангийн жилүүдэд өссөн дүнтэй байна.
- ГХС-ийн албан ёсны вэб сайт <http://fls.edu.mn/>, удирдлагын мэдээллийн системээр дамжуулан сургалтын үйл явц, бусад мэдээ мэдээллийг хүргэдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- 2017-2022 оны хичээлийн жилүүдэд ГХС-ийн ГХО (англи хэл) хөтөлбөрт 125 оюутан элсэн орж суралцсанаас 71 төгсөж, 60 оюутан суралцаж байна.
- Шинэ элссэн оюутны сурах үйл ажиллагааг дэмжиж, хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн мэдлэг мэдээлэл олгодог.
- Элсэгч оюутныг сургуулийн сургалтын алба бүртгэн, оюутны код олгож, хариуцан ажиллах салбар, зөвлөх багш руу илгээдэг. ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу оюутан бүрт зөвлөх багш томилогддог.
- Шинэ элсэгчдэд зориулсан гарын авлагад сургуулийн үйл ажиллагаа, оюутны бусад үйлчилгээний үйл ажиллагаа, дүрэм журам, зөвлөмж байдаг ба 2015 оноос цахим хэлбэрт шилжүүлсэн нь хүртээмжтэй төдийгүй орон зай цаг хугацаанаас үл хамааран хэрэгтэй мэдээллээр шуурхай хангах боломж олгосон байна. <https://www.must.edu.mn/uploads/2023/01/19/garin-awлага-2022-5.pdf>.
- 2020 оноос элсэгчдэд зориулан ЕБС-д сурагч, багш эцэг эхийн төлөөлөлтэй уулзалтууд зохион байгуулж 3000 гаруй сурагчдыг хамруулсан.
- Оюутнуудын хүсэл эрмэлзлэлд тулгуурлан урлаг спортын уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, сайн дурын олон нийтийн үйл ажиллагаа тогтмол зохион байгуулдаг.
- ШУТИС-ын оюутны үйлчилгээний алба [www.must.edu.mn](http://www.must.edu.mn) сайтаар дамжуулан хувь хүний хөгжил төлөвшилд чиглэсэн сургалтыг салбарын мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулдаг.
- Карьер хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд шилдэг төгсөгч мэргэжилтнүүдтэй уулзалт зохиодог.
- Оюутны судалгааны ажилд ач холбогдол өгснөөр тайлангийн хугацаанд 8 төгсөгч бакалаврын диплом бичиж амжилттай хамгаалсан.
- “Орлоготой оюутан” хөтөлбөрийн хүрээнд ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба Нийслэлийн хөдөлмөр, эрхлэлтийн газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд оюутнуудыг байнгын болон цагийн ажлын байранд зуучилдаг.
- Танилцах болон мэргэжлийн дадлагыг “Барловорлд Монголиа ХХК”, “Технож Инкубатор ХХК”, “Мон Энержи Консалт ХХК”, “Цэцүүх Трейд ХХК”, “Дулааны цахилгаан станц 4”, “Мон Соорс ХХК”, “Харилцаа холбоо ХХК” зэрэг техник технологийн олон байгууллагатай хамтран үр дүнтэй сайн зохион байгуулсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Шинээр элссэн оюутанд үзүүлдэг зөвлөх үйлчилгээ үр дүн сайн байна.

**Анхаарах асуудал:**

- Оюутны сайн дурын ажилд бодит дэмжлэг, хөтөлбөрийн оюутны нийгмийн хариуцлагын асуудал

### **Зөвлөмж:**

- Оюутны сайн дурын ажилд бодит дэмжлэг үзүүлж, хөтөлбөрийн оюутны нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХХШС-аас уламжлал болгон олон төрлийн хурал, олимпиад, уралдаан тэмцээн, спорт урлагийн наадам, ЭШХ-ууд зохион байгуулдаг.
- Оюутнуудыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцахад чиглэсэн орос-англи, герман хэлний сайн дурын 2 клубыг ажиллуулдаг.
- Оюутнуудыг ирээдүйн чиг хандлагаа тодорхойлоход туслах зорилгоор Карьер хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд шилдэг төгсөгч, оюутнууд төдийгүй амжилттай ажиллаж байгаа төлөөлөлтэй уулзалт зохион байгуулдаг.
- Оюутны хөгжлийг дэмжин идэвхжүүлж, Орос хэл соёлын, Герман хэлний клуб ажиллуулж нийт оюутны 20 хувь нь хамрагдаж байна.
- Тэргүүний оюутны сурах үйлсийг тэтгэх зорилгоор төрийн болон гадаад, дотоодын байгууллагаас олгодог тэтгэлэгт оюутнуудаа тогтмол хамруулдаг.
- Оюутнуудын нийгмийн идэвх, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор олон улсын уралдаан тэмцээнд амжилттай оролцсон, сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудад ШУТИС-ийн кредитийн урамшуулал, ШУТИС-ийн салбар захирлын тушаалаар тэтгэлэг хөнгөлөлт олгодог. Тайлангийн хугацаанд 34 оюутан аль нэг тэтгэлэгт хамрагдсан байна.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хэрэгжүүлснээр 13 оюутан үнсэн болон цагийн ажил эрхэлж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөнд хамруулж, оюутны сурах, өөрийгөө хөгжүүлэх үйлсийг дэмждэг.

### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Англи хэлний ангийн оюутны шилжилт хөдөлгөөн бусад сургууль руу шилжсэн нь 2017~2020 онд 11 байсан бол сүүлийн 2 жилд ийм хөдөлгөөн гараагүй байна.

- Оюутны шилжилт хөдөлгөөн тогтвортой болсон.
- Суралцагчийн шилжиж ирэх хөдөлгөөнийг дэмжих, шалгуурт заасны дагуу кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэрэг асуудлыг суралцагчийн эрх ашигт нийцүүлэн “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу шийдвэрлэдэг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Төгсөгчдийн бичиг баримтыг дээд боловсролын тухай хуульд заасан стандартын дагуу ШУТИС-ийн “БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ” зааснаар стандартын дагуу олон улсын жишигт нийцүүлэн олгодог.
- ШУТИС-ийн “БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ”-н 13, 14,15,16,17-р бүлэгт зааснаар бакалаврын зэрэг олгох сургалтын хувьд боловсрол олгох агуулгын багтаамж 128 кредит цагийг гүйцэд судалсан, суралцсан хугацааны хуримтлуулсан голч дүн 2.0 болон түүнээс дээш үнэлгээтэй суралцсан тохиолдолд төгсөлтийн баримт бичгийг олгодог.
- ГХС-ийн сургалтын алба, сургалтын төлөвлөгөөнд тусгасан зохих кредитийг гүйцээж, сурлагын үнэлгээний голч дүн 2.0- ээс багагүй оюутныг төгсөх оюутнаар бүртгэн авч, төгсөлтийн шалгалт, дипломын төслийн аль нэгийг гүйцэтгэж зохих үнэлгээ авсан төгсөгчид бакалаврын диплом олгох тушаал гаргадаг.
- ШУТИС-ын Ректорын тушаалаар бакалаврын кээргийн диплом олгодог.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- ГХО хөтөлбөрт багшийг, 2018 оноос эхлэн ШУТИС-ын Захирлын 2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн А\168 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”, 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А\232 тоот тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам”-ыг тус тус үндэслэн сонгон шалгаруулж авдаг.
- Боловсролын салбарт олон жил ажилласан туршлагатай багш нарын бүрэлдэхүүнтэй.
- Багшийн сонгон шалгаруулалтыг явуулах, зэрэглэл тогтоох, урамшуулал олгох зэрэг үйл ажиллагаа нь зохих журмын дагуу хэрэгждэг.
- Гадаад хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын зохих оноог шаарддаг.
- АНУ-ын мэргэжилтэн 4 багш ажиллаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Анхаарах асуудал:**

- Докторын зэрэг хамгаалсан багш нарын эзлэх хувь багассан, тайлант хугацаанд багш нарын албан тушаалын зэрэглэл дорвитой ахиагүй.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн багийн зүгээс багш нарын албан тушаалын зэрэглэлийг тогтмол ахиулж байх талаар анхаарах.

### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Нээлттэй боловсролын төв, Багшийн хөгжлийн төв профессор багшийн тасралтгүй хөгжих орчинг бүрдүүлэх, мэргэжлийн чадавхыг сайжруулахад гол түлхэц болдог.
- Багш нарын тасралтгүй хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд захиргааны зүгээс байнга анхаарч, томоохон сургалтуудыг зохион байгуулснаар багш нар Google application хэрэглээг нэмэгдүүлж, Teams, Moodle, LMS, Forms сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж хэвшиж байна.
- ГХС, БХБаг нь хамтын гэрээнд заасны дагуу жил тутам нийт багш, профессор, ажилтнаа эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг. /Нэг багшийн 40000₮ санхүүжилтийг багшийг дэмжих сангаас гаргадаг/. 2018, 2021 онд “Сөүл” эмнэлэгт 93, 74 багш ажилтан, 2022 онд “Хатагтай”, “Хөхний клиник” эмнэлэгт 60 багш ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.
- Багш докторын сургалтад 50%-ийн хөнгөлөлттэй суралцдаг нь багшийн чанар, зэрэг цолтой багшийн эзлэх хувьд нөлөө үзүүлдэг.

- 2017-2022 онд давхардсан тоогоор гадаадын урт, богоно хугацааны 13, дотоодын 268 нийт 281 мэргэжил дээшлүүлэх сургалтад нийт дахардсан тоогоор 1305 профессор хамрагдсан судалгаа байна.
- Салбарын багш нарын хамрагдсан нийт сургалтын 90% нь мэргэжлийн болон багшийн заах арга зүйн ур чадварыг сайжруулах, 10% нь хувь хүний хөгжлийн сургалтууд байв. Үүнээс дурьдвал /зөвхөн тус салбарын/ 2019 08 сард 5 багш Буриадын улсын их сургуульд 14 хоногийн орос хэл, заах арга зүйн, 2019.11 сард 5 багш Солонгос улсын Жиньжу их сургуульд 10 хоногийн англи хэл заах арга зүйн сургалтад хамрагдсан байна. Сургалтын зардлыг тус сургуультай байгуулсан гэрээний дагуу БУИС, Солонгосын Жиньжугийн их сургууль хариуцсан ба ГХС нь замын зардлын 50%-ийг гаргасан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Анхаарах асуудал:**

- Гадаад, дотоодын судалгааны нийгэмлэгт гишүүнчлэлтэй багшийн тоо цөөн.

#### **Зөвлөмж:**

- Гадаад, дотоодын судалгааны нийгэмлэг, мэргэжлийн холбоодод гишүүнчлэлтэй багш нарын хувийг нэмэгдүүлэх.
- Хөтөлбөрийн багш нар англи хэлээр яригч улс орнуудад англи хэлний мэргэжил дээшлүүлэх, суралцах, харилцан туршлага солилцох чиглэлээр идэвх санаачлагатай ажиллах

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Судалгаа туршилт хийх бодлогын баримт бичиг, дүрэм журмыг боловсруулсан, ШУТИС - д судалгааны профессорын баг байгуулж, ажиллуулах түр журам /А/24, 2015 - 02 - 06/ , ШУТИС - ийн Технологийн сангийн журам /А/69, 2012 - 04 - 19/ , ШУТИС - ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, гэрээт ажил гүйцэтгэх журам /А/46, 2018 - 03 - 12/ , ШУТИС - ийн Технологи дамжуулах журам /А/48, 2018 - 03 - 16/ • ШУТИС - ийн дэргэд гарааны компани байгуулж, ажиллуулах журам зэрэг бодлогын баримт бичгүүд, түүнд тусгагдсан заалтуудаар зохицуулдаг
- Жил бүр багш судлаачдын судалгаа шинжилгээний ажлыг хэлэлцүүлж шалгаруулдаг, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл гаргадаг.
- ХХШС-ын эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлээ нэр томъёо судлал, орчуулга, хэрэглээний хэл шинжлэл, зэрэгцүүлсэн хэл зүй, гадаад хэл заах арга зүй, өвөрмөц хэлц судлал гэж томъёолж багш нар идэвхтэй оролцдог.
- ХХШС-аас 2019 онд “Нэр томъёо судлалын асуудалд” ЭШБичиг, 2021 онд “Хэрэглээний хэл шинжлэлийн асуудалд” ЭШБичиг эрхлэн гаргасан.



- 2017- 2022 онд салбарын профессор багш нарын 21 бүтээл зохиогчийн эрхийн гэрчилгэ авсан байна.
- Тайлант хугацаанд тус хөтөлбөрийн хамт олон гадаадад 2 илтгэл, дотоодод 88 илтгэл, 189 өгүүлэл, нийт 93 илтгэл хэлэлцүүлж, 239 өгүүлэл нийтлүүлсэн байна.
- ХХШС-ын профессор багш нар тайлангийн хугацаанд 29 төсөл, гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- Сургуулийн жилийн төсөвт эрдэм шинжилгээний ажлын зардлыг сүүлийн 5 жилээр аргасан бөгөөд судалгаанаас үзэхэд сүүлийн жил буюу 2022 онд жилийн төсөвт эзлэх хувийн жин 1.03% болж өссөн үзүүлэлттэй байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Профессор багш нарын ажлын ачаалалд судалгааны ажлын эзлэх хувь ахлах багшаас зөвлөх профессор 20-25 хувийг эзэлдэг, эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлдэг систем бүрдсэн.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Багшийн өөрийн үнэлгээ, оюутны сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн.
- Багш нар гүйцэтгэх ёстой 3 чиглэлээр өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэлээ тооцуулдаг.
- 2016-2017 оны хичээлийн жилээс ШУТИС-ийн багш нарын өөрийн үнэлгээний системийг цахим хэлбэрт шилжүүлсэн ба энэхүү систем нь багшлах үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ болон нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг үнэлэх 3 дэд бүлэг, 1000 оноогоор үнэлэх үнэлгээний асуумж, нотолгоог татаж оруулах бүтэцтэй.
- Багш хичээлийн жилд гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал авах боломжтой.
- ШУТИС нь “CLOUD UNIMIS” программыг хөгжүүлэн ашиглалтад оруулсан бөгөөд 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн оюутнуудаар хичээл заасан багшийг үнэлүүлэх ажлыг туршиж эхэлсэн. Суралцагчаас авдаг судалгаа нь 0-5 үнэлгээ бүхий 9 асуумжаас бүрддэг.
- Хөтөлбөрт багш нарт өгсөн оюутны үнэлгээ сүүлийн 4 жилээр гаргасан бөгөөд судалгаанаас үзэхэд хөтөлбөрийн багш нарт хангалттай үнэлгээ өгч байгаа нь харагдаж байна.
- Хамтын гэрээний дагуу багш хичээлийн жилд 2 удаа өөрийн хийсэн ажлыг тайлагнаж, салбарын эрхлэгч хянаснаар цалингийн 100 хүртэлх хувиар урамшуулал авдаг. Хичээлийн улирал тутам 20-30 багш цалингийн 25-50 хувийн урамжуулал авчээ.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

## **6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ШУТИС нь 2023.01.06-ны өдөр Боловсролын байгуулагын менежментийн тогтолцооны Олон улсын ISO 21001:2018 стандартын гэрчилгээ авч, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт хэмжил зүйн газраас баталгаажуулсан анхны их сургууль болсон.
- ШУТИС-ийн чанарын тогтолцоо бий болгож, үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлгээг тасралтгүй явуулах чиглэлээр дотооддоо болон хөндлөнгийн байгууллагаар чанараа баталгаажуулах, түүнийг нийтэд мэдээлэх үүрэг бүхий бүтцийн нэгжүүдийг үе шаттай байгуулж байна. ШУТИС-ийн Захирлын 2018 оны 1 дүзгээр сарын 31 - ний өдрийн тушаалаар “Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба” байгуулагдсан үүрэг тодорхойлогдсон.
- ШУТИС нь дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэхийн тулд багш, салбар, тэнхим, бүрэлдэхүүн сургууль, их сургуулийн гэсэн 4 түвшинд үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.
- ГХС-ийн Захирлын зөвлөлийн 2021.06.10 өдрийн хурлын шийдэрээр ГХС-ийн чанарын багийг байгуулсан ба ГХС-ийн Захирлын 2023.02.03-ны өдрийн тушаалаар дэмжих багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ШУТИС нь Боловсролын байгуулагын менежментийн тогтолцооны Олон улсын ISO 21001:2018 стандартын ханган ажиллаж буй анхны их сургууль болсон сайн туршлага нь тухайн хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх чанарын баталгаажуулалтыг хангах боломжийг бүрдүүлж байна.
- ГХС нь 2022-2026 оны 4 жилийн Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

#### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

### **Илрэл нотолгоо:**

- 2017-2022 оны хичээлийн жилд хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн мөшгөх судалгааг хийсэн. Уг судалгаанд хамрагдсан хуучин ТМО (англи хэл) мэргэжлийн 35, ГХО (англи хэл) хөтөлбөрөөр 36 хүн төгссөн ба нийт төгсөгчдийн 84% ажил эрхэлж байгаагаас 10% мэргэжлийн ажил, 23% мэргэжилтэй холбоотой ажил, 25% бусад мэргэжлийн ажил хийж байна.
- ТТО мэргэжлийн төгсөгчдийн 51% нь шууд ажилласнаас 43% Улаанбаатар хотод ажил эрхэлж байгаагаас 42% 1-12 сар, 13% нь 13-14 сар, 2% нь 2-оос дээш жил ажиллаж байна.
- Нийт төгсөгчдийн 11% нь төгсөөд 1-2 сар, 6% нь 5-6 сар, 4% нь 12 сарын дараа ажил эрхэлсэн.
- Ажил олгогч 8 байгууллагаас сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаан дүнгээр ажил олгогчдын хэрэгцээ шаардалагад хэр зэрэг нийцэж буй байдлын асуулгад 50%-иас дээш хувь нь сайн, 10 %-с дээш хувь маш сайн бусад нь дунд гэж үнэлсэн.
- Хөтөлбөрийн үр дүн 2017-2022 онд төгсөгчдийн байдлыг тандах зорилгоо ажил олгогчдоос манлайлах ур чадвар, бие даан ажиллах чадвар, багаар ажиллах чадвар, бичих чадвар, ярианы чадвар, компьютер интеонет ашиглах чадвар, тухайн ажил мэргэжлийн мэдлэг, бизнес эрхлэх ур чадвар гэсэн 8 асуулгаар санал асуулга явуулж 1-5 баллын үнэлгээгээр дүгнэсэн. Энэхүү асуулгаар 2017-2020 оны төгсөгчид ихэнх ур чадварт 4-5 гэсэн үнэлгээ өгсөн байхад 2020-2022 төгсөгчдийн үнэлгээ 3-4 болж буурсан шалтгаан нь Ковид цар тахлын үеийн цахим сургалтаас хамаарч харилцаа, багийн ажиллагаа дутмаг байсан гэж үзсэн байна.
- Мэргэжлийн холбоод, дадлага хийлгэж буй байгууллагуудаас санал асуулга авсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн оролцогч талууд буюу төгсөгч ажил олгогчдын оролцоог тогтмолжуулж идэвхжүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Төгсөгч буюу ажил олгогчдын санал зөвлөмжийг олон хэлбэрээр авч хөтөлбөрийн үр дүнг сайжруулахад тусган хэрэгжүүлж, үр дүнг тооцдог байх

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- 2020 онд ШУТИС-ийн Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба нь ШУТИС-ийн бүх салбар, тэнхимийн 2017-2020 оны 3 жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг бичүүлж, үнэлж дүгнэсэн ба ХХШС нь тайланг амжилттай хамгаалж, тавиагдсан шаардлагыг бүрэн хангансан.
- ГХС нь 2022-2026 оны Хөтөлбөрийн дотод чанарын баталгаажуулалтын 4 жилийн төлөвлөгөөг боловсруулсан.
- 2019-2022 онд төгсөгчдийн санал асуулгад оролцогчдоос 5 дотоодын их, дээд сургуульд, АНУ, Япон, Ирланд, Солонгос зэрэг оронд 4 төгсөгч ахисан түвшний сургалтад суралцсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.**

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт суралцагч, төгсөгчдийн цогц чадамжуудыг үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэлээр хийгдэх ажлууд.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрт суралцагч, төгсөгчдийн цогц чадамжуудыг үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцдог байх
- Хөтөлбөрийн төгсөгчдийн судалгааг тогтмол явуулж, үндэсний болон олон улсын түвшинд амжилттай суралцаж, ажиллаж буй төгсөгчдийн судалгааг гаргаж, тэдний туршлагыг хуваалцан алдаршуулдаг байх

**7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

**ДҮГНЭЛТ**

.....

Шалгуур	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангааг үй	Үндэслэл, шалтгаан /Хэсэгчлэн хагасан болон хангаагүй үед/
1. Хөтөлбөрийн төлөвлөлт	3	-	-	-
2. Сургалтын үйл ажиллагаа	3	-	-	-
3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн	3	-	-	-
4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1 (4.4)	-	Маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр боловсруулалт, үр дүнд сул.  Элсэлтийн бодлого, үйл ажиллагаанд хөтөлбөрийн онцлог, давуу талаа илүү тодорхойлж түүнд нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах үнэлэх тал дээр сул анхаарсан.
5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5	-	-	-
6. Багшийн үйл ажиллагаа	4	-	-	-
7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1 (7.3)	-	Хөтөлбөрт суралцагч, төгсөгчдийн цогц чадамжуудыг үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэлээр хийгдэх ажлуудад сул анхаарсан.
<b>Дүгнэлт</b>	<b>Бүрэн хангасан.</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийн Гадаад хэлний сургуулийн “Гадаад хэлний орчуулга (Англи хэл)” бакаларын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж буй тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг Хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

### ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

№	Шалгуур	Зөвлөмж	Шаардлага
1.	Хөтөлбөрийн төлөвлөлт	- Сургалтын хөтөлбөрт орсон өөрчлөлт бүрийг баримтжуулж, өөрчлөлт хийх болсон шалтгаан, үндэслэл, анализ зэргийг хангалттай тусгаж байх	
2.	Сургалтын үйл ажиллагаа		
3.	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл		
4.	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	- Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээнд хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог тогтмолжуулж, идэвхжүүлэх - Хөтөлбөрийг илүү үр дүнтэй үндэсний хэмжээнд жишиг болохуйц үр дүнд хүргэх маркетингийн бодлого төлөвлөгөө боловсруулах - Хөтөлбөрийн онцлог, давуу тал, хүрэх үр дүн, хэрэгцээ шаардлага, хөдөлмөр эрхлэх боломж г.м. элсэлтийн үр дүнд нөлөөлөх чухал мэдээллүүдийг үндэсний болон олон хэмжээнд олон нийтэд хүргэх олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, томоохон хэмжээний үзэсгэлэн, мэргэжил сурталчлах өдөрлөг, тэмдэглэлт үйл явдлууд зэрэг олон хэлбэрийн үйл ажиллагааг явуулах	
5.	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	- Оюутны сайн дурын ажилд бодит дэмжлэг үзүүлж, хөтөлбөрийн оюутны нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх	

6.	Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн багийн зүгээс багш нарын албан тушаалын зэрэглэлийг тогтмол ахиулж байх талаар анхаарах.</li> <li>- Гадаад, дотоодын судалгааны нийгэмлэг, мэргэжлийн холбоодод гишүүнчлэлтэй багш нарын хувийг нэмэгдүүлэх.</li> <li>- Хөтөлбөрийн багш нар англи хэлээр яригч улс орнуудад англи хэлний мэргэжил дээшлүүлэх, суралцах, харилцан туршлага солилцох чиглэлээр идэвх санаачлагатай ажиллах</li> </ul>	
7.	Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>- Төгсөгч буюу ажил олгогчдын санал зөвлөмжийг олон хэлбэрээр авч хөтөлбөрийн үр дүнг сайжруулахад тусган хэрэгжүүлж, үр дүнг тооцдог байх</li> <li>- Хөтөлбөрт суралцагч, төгсөгчдийн цогц чадамжуудыг үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцдог байх</li> <li>- Хөтөлбөрийн төгсөгчдийн судалгааг тогтмол явуулж, үндэсний болон олон улсын түвшинд амжилттай суралцаж, ажиллаж буй төгсөгчдийн судалгааг гаргаж, тэдний туршлагыг хуваалцан алдаршуулдаг байх</li> </ul>	

## V. Ярилцлагад оролцогчдын нэрс

### I. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	О.Наранцэцэг	магистр	Технологийн мэргэжлийн орчуулга
2	П.Хулан	4-р курс	Техник технологийн орчуулга
3	Б.Бат-Орших	4-р курс	Техник, технологийн орчуулга
4	Б.Цолмон	4-р курс	Техник, технологийн орчуулга
5	Р.Дэжидбал	3-р курс	Техник, технологийн орчуулга
6	Б.Санчир	3-р курс	Техник, технологийн орчуулга
7	Н.Анаршил	2-р курс	Техник, технологийн орчуулга
8	Э.Дагийранз	4-р курс	Техник, технологийн орчуулга
9	Г.Түмэндэлгэр	3-р курс	Техник, технологийн орчуулга
10	Х.Сугарбаатар	3-р курс	Техник, технологийн орчуулга
11	О.Цолмон	1-р курс	Техник, технологийн орчуулга
12	О.Гэрэлт-Од	1-р курс	Техник, технологийн орчуулга
13	Э.Аттила	1-р курс	Техник, технологийн орчуулга
14	Г.Сугар	1-р курс	Техник, технологийн орчуулга

15	Б.Жадамба	1-р курс	Техник, технологийн орчуулга
16	Б.Энхмаа	1-р курс	Техник, технологийн орчуулга
17	М.Анужин	4-р курс	Техник, технологийн орчуулга
18	Т.Арвин	2-р курс	Техник, технологийн орчуулга

### II. Багш, ажилтны нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Ц.Цэцэгмаа	Салбарын эрхлэгч			
2	С.Бархас	Профессор			
3	Э.Чимэдлхам	дэд профессор			
4	Б.Байгальмаа	ахлах багш			
5	Л.Амгалан	ахлах багш			
6	О.Золзаяа	багш			
7	Я.Оюунцэцэг	багш			
8	Б.Байгаль	ахлах багш			
9	С.Сэржмядаг	ахлах багш			
10	Д.Туяа	чанарын менежер			
11	Т.Энхцэцэг	багш			

### III. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал

### IV. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал

### V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

### VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр



Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## **ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**